



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 35

Төрийн ордон, Улаанбаатар хот

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолын 2 дахь заалтын 3 дахь дэд заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-ийг 1 дүгээр хавсралтаар,” “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-г 2 дугаар хавсралтаар,” “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-ийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх болон бусад төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл ажлыг хангаж ажиллах;

3/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д нийцүүлэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилттой уялдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газраас санаачилсан “Хүнсний хувьсгал” хөтөлбөр, “Цагаан алт” үндэсний хөтөлбөр, “Монголд зочлох жил”, “Залуучуудын жил”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин”, “Атар-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн бодлогын төсөл, арга хэмжээнүүдийг тусгалаа.

Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь “урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх” бөгөөд Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын үндсэн бодлогын хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлуудад үндэслэн тодорхойлж, шаардлагатай салбарын реформыг шуурхай эхлүүлж, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхийг зорилоо.

Эдийн засгийн бодлогын хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 онд бүрэн эхлүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зах зээл дэх төрийн оролцоог хялбарчлах, салбаруудад бодлогын цогц реформыг хийх шинэчлэлийн ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Эрчим хүч, зам тээвэр, хөдөө аж ахуй, банк, санхүүгийн салбарт бодлогын цогц шинэчлэл, либералчлалыг хэрэгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Уул уурхайн салбарын тусгай зөвшөөрлийг ил тод болгож, уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалдаг бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, биржийн тогтолцоог бэхжүүлнэ. Шинжлэх ухаан, технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулах бодлогыг хэрэгжүүлнэ.

Хувийн хэвшилд тулгуурласан бизнесийн орчныг дэмжиж, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн дижитал болон ногоон эдийн засгийг нутагшуулж, гарааны бизнес, инновацийг дэмжих бодлого, хөшүүргийг тодорхойлж хэрэгжүүлнэ.

Гадаад худалдааны техникийн болон тарифын саад бэрхшээлийг арилгаж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвар бүхий экспортыг нэмэгдүүлж, төрөлжүүлэх замаар олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, эдийн засгийг тэлнэ.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд байгалийн баялаг, нөөц, байршлын давуу талд тулгуурласан бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлж, бүс бүрд ач холбогдолтой томоохон төслүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлж, бүс, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бие даан хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ.

Орон нутгийн төвлөрлийг дэмжих хүрээнд нийслэл Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшиж байгаа иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх бодлогын дэмжлэгийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Нийслэл Улаанбаатар хотын “20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан “Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040” болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна. Дагуул хотуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлнэ.

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд иргэн бүр тэгш эрхтэйгээр нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах, орлого олох, хөгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн гэр бүл, хүүхэд, эхчүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан, залуучуудын онцлогт нийцүүлсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, тус сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд төлбөрийн чадварт нийцсэн орон сууц, байгальд ээлтэй амины орон сууцны хүртээмжийг бодлогоор дэмжинэ.

Хүн амын бүлгүүдийн онцлогт нийцүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэх зорилгоор бүх түвшний сургалтын байгууллагын чанар, суралцах орчныг сайжруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг эрчимжүүлнэ.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд төрийн албаны реформыг хэрэгжүүлж, чадварлаг, ухаалаг төрийн албаны тогтолцоог төлөвшүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний цахимжилт, процессын дахин инженерчлэлийг үргэлжлүүлж, шийдвэр гаргалт, үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлж, иргэдэд ойр төрийн үйлчилгээг бий болгоно.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, сайн засаглалын зарчмаар үйл ажиллагааг нь явуулна.

_Авлига, хүний эрх, хувийн эрх зүйн реформыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд тодорхойлсон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр улсын эдийн засаг 2025 онд 8 хувиар өсөж, экспорт 19.0 тэрбум ам.долларт хүрч, гадаад валютын улсын нөөц нэмэгдэж, инфляц зорилтот түвшинд хадгалагдаж, ядуурал буурч, хүний хөгжлийн индекс, засаглалын индексийн үзүүлэлт сайжирна.

Нэг.Эдийн засгийн бодлого

1.1.Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалж, өгөөжийг өрх бүрд хүргэнэ.

1.1.1.Эдийн засгийн өсөлтийг 2025 онд 8 хувьд хүргэж, инфляцыг Төв Банк /Монголбанк/-ны зорилтот түвшинд хадгална.

1.1.2.Төсвийн зарлага, татварын реформыг хэрэгжүүлэх хүрээнд урсгал зардлыг бууруулан, хөгжлийн төлөвлөлтөд чиглэсэн төсөвлөлтийн зарчмыг хэрэгжүүлнэ.

1.1.3.Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувийн ашигтай байхаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

1.1.4.Төв Банк /Монголбанк/-ийг төсвийн шинжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс татгалзуулж, инфляцыг зорилтот түвшинд тогтвортой хадгалахад мөнгөний бодлогын тохируулгыг төсвийн бодлоготой уялдуулж, цаашид инфляцын зорилтот түвшнийг үе шаттай бууруулах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.Эдийн засгийн тэргүүлэх салбарт реформыг хэрэгжүүлнэ.

1.2.1.Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

1.2.1.1.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.1.2.Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг хагас болон гүн боловсруулах, инновац, технологи шингээсэн “Цагаан алт” хөнгөн үйлдвэрийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.1.3.“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг үндэсний хэмжээнд өрнүүлж, “Чинээлэг малчин” болон “Малын эзэн-Үйлдвэрийн эзэн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.1.4.“Атрын-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг эхлүүлж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан тариалангийн газар, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

1.2.1.5.Хөдөө аж ахуйн салбар дахь татаас, хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээг эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын орчныг сайжруулахад чиглэсэн бодлогын цогц шинэчлэлийг эхлүүлнэ.

1.2.1.6.Хөдөө аж ахуйн хувийн биржийн үйл ажиллагааг дэмжиж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийг зах зээлийн зарчимд шилжүүлнэ.

1.2.1.7.Мал, амьтны өвчний тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлж, өвчний тархалтыг хязгаарлан, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын тайван бүсийн үзүүлэлтийг тогтвортой хадгална.

1.2.1.8.Мал, амьтны гоц халдварт өвчний вакциныг олон улсын стандартад нийцүүлэн дотоодод үйлдвэрлэнэ.

1.2.1.9.Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг мөшгөх системийг нэвтрүүлнэ.

1.2.1.10.Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг экспортод гаргах хэлцэл, хорио цээрийн протоколыг бүтээгдэхүүн тус бүрээр байгуулна.

1.2.1.11.Бэлчээрийн мал аж ахуйд тулгуурлан хосолсон мал аж ахуйг дэмжиж, хувийн хэвшлийг дэмжих замаар бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулна.

1.2.1.12.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад худалдааны хориг, хязгаарлалтыг цуцлах, уг бүтээгдэхүүнийг боломжит боомтуудаар экспортлох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.1.13.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрийг байгуулахыг бодлогоор дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.

1.2.2.Уул уурхайн тусгай зөвшөөрлийн олголт, уул уурхайн бүтээгдэхүүний ашиглалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх цогц реформыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.2.2.1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалдаг бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, биржийн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.2.2.Уул уурхайн тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үйл ажиллагааг ил тод, олон нийтэд нээлттэй болгоно.

1.2.2.3.Зөвч-Овоо ордын ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг эхлүүлнэ.

1.2.2.4.Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хүрээнд нүүрс-хими, кокс-химийн үйлдвэр, гангийн үйлдвэр, зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах 2 дахь үйлдвэрийн байршлыг эцэслэн тогтоож, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн газар зүйн байршлыг тогтоож, төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг эхлүүлнэ.

1.2.2.5.Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, түлш шатахууны стандарт “Евро 2”-оос “Евро 5”-руу шилжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.2.2.6.Алт цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг эхлүүлнэ.

1.2.2.7.Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.

1.2.2.8.Геологи, хайгуулын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр стратеги, бодлого боловсруулна.

1.2.2.9.Стратегийн ордуудаас Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх талаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

1.2.2.10.Геологийн мэдээллийн ил тод байдлыг зохих түвшинд хангана.

1.2.2.11.Геологи, хайгуулын салбарт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, улмаар ашигт малтмалын нөөцийг өсгөнө.

1.2.3.Тээвэр, логистикийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

1.2.3.1.Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн “Гашуунсухайт-Ганцмод”, “Шивээ хүрэн-Сэхээ” боомтуудын хил дамнасан төмөр замын төслийн барилгын ажлыг эхлүүлж, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих төслийг хэрэгжүүлж, “Ханги-Мандал” боомтын хил дамнасан төмөр замыг холбох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.3.2.Төмөр замын төв коридорыг шинэчлэх ажил болон баруун, зүүн босоо тэнхлэгийн төмөр замыг барих ажлыг эхлүүлнэ.

1.2.3.3.Хилийн боомт, аялал жуулчлалын бүс, аймаг, сумдыг холбосон “Шинэ сэргэлтийн Таван тойрог” авто замын төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.2.3.4.Боомтын шинэчлэлийг үргэлжлүүлж, хилийн боомтуудын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадал холболтыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ /Шивээхүрэн, Сүмбэр, Ульхан, Ханги, Эрээнцав, Бургастай, Даян/.

1.2.3.5.Цагаандэл-Уул боомтын үйл ажиллагааг эхлүүлж, Бичигтийн боомтын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

1.2.3.6.Цагаандэл-Уул боомт хүртэлх дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ.

1.2.3.7.Алтанбулаг боомтын зорчигч тээврийн цогцолборын барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.

1.2.3.8.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөлийн ажлыг эхлүүлнэ.

1.2.3.9.Аймаг, сумын төвүүдэд хуурай боомт байгуулж, орон нутагт гаалийн бүрдүүлэлт хийх боломжийг бүрдүүлнэ.

1.2.3.10.Төмөр замын тээврийн үнэ, тарифыг зах зээлийн зарчимд нийцүүлэн үр ашигтай болгох бодлогыг үргэлжлүүлнэ.

1.2.3.11.Дорнод аймгийн Буйр нуур орчимд 4С нисэх буудал барих ажлыг эхлүүлнэ.

1.2.3.12.“Хөшигийн хөндий-Замын-Үүд” чиглэлийн тусгай зориулалтын авто замын төслийг эхлүүлэх бэлтгэлийг хангана.

1.2.3.13.Замын-Үүд, Алтанбулаг болон бусад чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөгөөг сайжруулж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

1.2.3.14.Олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграцид дэд бүтцийн сүлжээгээр холбогдож, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

1.2.3.15.“Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүс нутгуудын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрчимжүүлнэ.

1.2.4.Эрчим хүчний реформыг хэрэгжүүлж, найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

1.2.4.1.Эрчим хүчний тарифыг шинэчилж, тогтмол индексжүүлнэ. Тус салбарыг хувийн хөрөнгө оруулалт татах чадвартай бие даасан эдийн засгийн салбар болгон хөгжүүлэх хүрээнд хууль, эрх зүйн орчныг шинэчлэх ажлыг эхлүүлнэ.

1.2.4.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.

1.2.4.3.Бөөрөлжүүтийн 300 МВт-ын дулааны цахилгаан станц төслийн хоёрдугаар ээлжийн 150 МВт-ын хүчин чадалтай блоккийг ашиглалтад оруулна.

1.2.4.4.Эгийн голын усан цахилгаан станцын төслийн хэлэлцээрийн явцыг идэвхжүүлнэ.

1.2.4.5.Ердийн ачааллын үеийн цахилгааныг хуримтлуулж, оргил ачааллын үед төвийн системд нийлүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.

1.2.4.6.Нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн, дулааны станцууд болон хотын дэд төвүүдийн дулааны станцуудыг үе шаттайгаар барина.

1.2.4.7.Эрчим хүчний дамжуулах, түгээх шугам сүлжээг өргөтгөн шинээр байгуулж, эрчим хүчний найдвартай байдлыг хангах төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ.

1.2.4.8.Сэргээгдэх эрчим хүч, тархмал эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх төслүүдийн хүчин чадал, цар хүрээ, байршлыг тодорхой болгох, хэрэгжүүлэх, төвлөрсөн дулаан хангамжийн системгүй аймгийн төвүүдэд дулааны станц барих ажлыг үргэлжлүүлэх, холбогдох төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, шинэчлэх ажлыг эхлүүлнэ.

1.2.4.9.Иргэн, аж ахуйн нэгж сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэж хэрэглэх, хэрэгцээнээс давсан хэсгийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх, худалдах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.5.Аялал жуулчлалыг дэмжих ажлын хүрээнд:

1.2.5.1.“Go Mongolia” үндэсний брэндийг олон улсын түвшинд таниулах, нэгдсэн платформ бүтээх замаар олон улсад Монгол Улсын сурталчилгаа, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.2.5.2. Агаарын тээврийн реформыг үргэлжлүүлж, нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, орон нутгийн болон олон улсын нислэгийн тоо, чиглэл, давтамжийг нэмэгдүүлнэ.

1.2.5.3. Визийн хөнгөлөлтийг үргэлжлүүлж, түр чөлөөлсөн улсуудын визийг бүрэн чөлөөлнө.

1.2.5.4. Дөрвөн улирлын аялал жуулчлалын нэгдсэн төлөвлөлтийг баталж, идэвхтэй болон идэвх багатай улирлаар ялгаатай бодлого хэрэгжүүлэх, дөрвөн улирлын турш ашиглах боломжтой орчин үеийн спорт, амралт, чөлөөт цагийн цогцолбор болон шинэ цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулах бэлтгэл ажлыг хангана.

1.2.5.5. Дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд гол чиглэл, олон улсын авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулна.

1.2.5.6. Аялал жуулчлалын авто зам дагуух зорчигч үйлчилгээний цогцолбор, амрах талбайг нэмэгдүүлэх ажлыг дэмжинэ.

1.2.5.7. Түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс, аялал жуулчлалын томоохон парк, цогцолборыг бүсчилсэн хөгжлийн хүрээнд байгуулна.

1.2.5.8. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл /тусгай сонирхлын, хил орчмын/-ийг нэмэгдүүлнэ.

1.2.5.9. Монгол орны онцлог, өв уламжлалыг олон улсын экспо, маркетинг, зар сурталчилгаа зэрэг олон төрлийн суваг, арга хэрэгслээр дамжуулан дэлхийд сурталчилна.

1.2.5.10. Дотоодын аялал жуулчлалыг идэвхжүүлэх бодлого, хөшүүргийг тодорхойлж, хэрэгжүүлнэ.

1.2.6. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд:

1.2.6.1. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

1.2.6.2. Монгол Улсад гадаадын контент бэлтгэх төслийг бодлогоор дэмжиж, дэлхийн нэр хүндтэй томоохон компаниудтай хамтарсан төсөл эхлүүлнэ.

1.2.6.3. Соёлын биет болон биет бус өвийг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэд бүтцийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.2.6.4. Өөрийн орны өвөрмөц онцлог, нөөц, олон улсын чиг хандлага, технологийн хөгжилтэй уялдсан, мэдлэгт суурилсан бүтээлийг дэмжиж, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

1.3. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна.

1.3.1. Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын зах зээлийг өргөжүүлэх ажлын хүрээнд:

1.3.1.1.“Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”, “Монгол Улс, Евро-Азийн эдийн засгийн холбоо хоорондын чөлөөт худалдааны хэлэлцээр”, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлыг эхлүүлнэ.

1.3.1.2.Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улстай Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулна.

1.3.1.3.Гадаад худалдааны баримт бичгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтад зарцуулж байгаа хугацааг бууруулж, үйл ажиллагааг цахимжуулан, “Гадаад худалдааны цахим нэг цонх” мэдээллийн системийг нэвтрүүлнэ.

1.3.1.4.Гадаад худалдаа эрхлэгчдэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийг багасган, шаардлагагүй баримт бичгийн тоог цөөлж, давхардлыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.

1.3.1.5.Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж, гаалийн хяналт, шалгалтын тоог бууруулан, эдгээр үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчныг боловсронгуй болгон гаалийн үйл ажиллагааг хөнгөвчилнэ.

1.3.1.6.Тохирлын үнэлгээнд заавал хамрагдах бараа, үйлчилгээний жагсаалтыг зах зээлийн зарчимд нийцүүлэн шинэчлэн, зохицуулалтыг боловсронгуй болгоно.

1.3.1.7.Худалдааны түнш улс орнуудын зах зээлд бүтээгдэхүүн экспортлоход дэмжлэг үзүүлэх “Судалгаа, хөгжүүлэлтийн төв”-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

1.3.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд:

1.3.2.1.Бизнес эрхлэх орчны цогц үнэлгээг хийж, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг сайжруулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.3.2.2.Бизнес эрхлэхэд учирч байгаа хууль, эрх зүйн зохицуулалтад тулгарч буй асуудлыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.

1.3.2.3.Монополын эсрэг стратегийг боловсруулж, зах зээлийн өрсөлдөөнийг дэмжсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.3.2.4.Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, зохицуулалтыг хялбарчилж, салбаруудын болон хувийн хэвшлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ.

1.3.2.5.Төрөөс хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, гэрээгээр гүйцэтгүүлж болох төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.

1.3.2.6.Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан хүний оролцоо, хүнд суртлыг арилгана.

1.3.2.7.Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчит компани болон компанийн нэгдэл хэлбэрээр ажилладаг төрийн өмчит компанийн үйл ажиллагааг уялдуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай зарим компанийг олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.

1.3.2.8.Эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг оновчтой тодорхойлж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох оролцогчдын хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож, хиймэл оюун ухааныг ашиглана. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог оновчтой болгоход хиймэл оюун ухааныг ашиглана.

1.3.2.9.Бизнес эрхлэхэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийг арилгах, хүний нөөцийн тулгамдсан асуудалтай холбогдуулан гадаадаас авах ажиллах хүчний хязгаарлалт, ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх асуудлыг бодлогоор дэмжиж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг тогтворжуулна.

1.3.2.10.Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулна.

1.3.2.11.Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх нэг цонхны бодлогыг боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, судалгааны ажлыг зохион байгуулна.

1.3.2.12.Бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэгийг оновчтой болгох, тухайлсан салбарын татварын ачааллыг бууруулах бодлогыг боловсруулж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

1.3.2.13.Татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх чиглэлд хариуцлагатай татвар төлөгчийг дэмжиж, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.

1.3.3.Банк, хөрөнгийн зах зээлийн реформ хэрэгжүүлэх хүрээнд:

1.3.3.1.Санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, реформыг хэрэгжүүлнэ.

1.3.3.2.Гадаад улсын банкны салбар, нэгжийг дотоодын зах зээлд нэвтрүүлж, банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж, иргэд, хувийн хэвшилд олгох зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.3.3.Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг экспорт-импортын банк болгон өргөжүүлэн зохион байгуулж, засаглалыг сайжруулна.

1.3.3.4.Төрийн банкиг Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ногоон хөгжлийн бодлогыг эрчимжүүлэх, байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжихэд чиглэсэн тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулна.

1.3.3.5.Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн оролцогчдын хүрээг тэлэх бодлого хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах татварын таатай орчныг бүрдүүлнэ.

1.3.3.6.Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд шударга өрсөлдөөнийг бий болгож, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.

1.3.3.7.Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системийн цогц шинэчлэлийг хэрэгжүүлж, олон улсын стандарт бүхий нэгдсэн шийдлийг зах зээлд нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

1.4.Ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангана.

1.4.1.Ногоон эдийн засаг, ногоон шилжилтийн реформыг хэрэгжүүлэх хүрээнд:

1.4.1.1.Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна.

1.4.1.2.Эрчим хүчний хэмнэлттэй, гамшигт тэсвэртэй, дэвшилтэт технологи бүхий амины болон нийтийн орон сууц, дэд бүтцэд олгох ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.4.1.3.Ногоон хэрэглээг нэмэгдүүлэх бодит хөшүүргүүдийг үе шаттай бий болгож, төрийн худалдан авалтад ногоон худалдан авалтыг дэмжинэ.

1.4.1.4.Байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай үйлдвэр, технологийг хөгжүүлэн, ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4.1.5.Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн төслийг үргэлжлүүлж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ.

1.4.1.6.Цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг шинээр байгуулж, бие даасан, бага оврын ариун цэврийн байгууламжийн хэрэглээг бодлогоор дэмжинэ.

1.4.1.7.Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг нэвтрүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

1.4.1.8.Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.1.9.Хог шатаах аргаар эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн төслийг дэмжинэ.

1.4.1.10.Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлнэ.

1.4.2. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ажлын хүрээнд:

1.4.2.1. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлд тулгуурласан “Стандарттай байгаль орчны салбар” төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.

1.4.2.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх суурь конвенцын Талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ыг 2026 онд нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана.

1.4.2.3. Хот, суурин газруудын хог хаягдлын менежментийг сайжруулж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.4.2.4. Орчны бохирдлыг бууруулах, байгальд ээлтэй техник, технологийг нэвтрүүлэх, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

1.4.2.5. Зүүн Азийн улс орнуудтай хамтран “Шар шороон шуурга”-ны нүүдлийг зогсоох, цөлжилтийн эсрэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.2.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, тариалангийн бүс нутгийн агро-ойжуулалтыг эрчимжүүлнэ.

1.4.2.7. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойн хомсдол, доройтлыг бууруулахад ухаалаг, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

1.4.2.8. Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.

1.4.2.9. Усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж, усны чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.2.10.Байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан санг байгуулж, иргэд, мал аж ахуй, зэрлэг амьтан, үйлдвэрлэлийн ус хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.4.2.11.Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын ундны гүний усны нөөц ашиглалтыг үе шаттайгаар бууруулж, гадаргын ус ашиглах, усыг дахин ашиглахыг дэмжинэ.

1.4.2.12.Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сүргийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг нэгтгэсэн стандартыг нэвтрүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулна.

1.4.2.13.Гэрээний дагуу бэлчээрийн даацаа хэтрүүлээгүй, малаа зөв зохистой маллаж, бэлчээр хамгаалж байгаа малчдыг бага хүүтэй ногоон зээлд хамруулах боломжийг банк, санхүүгийн байгууллагатай хамтран бүрдүүлнэ.

1.4.2.14.Бэлчээрт хөнөөл учруулж байгаа хортон шавж, мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэхэд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

1.4.2.15.Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтоох судалгааг үргэлжлүүлж, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.5.Шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурласан мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлнэ.

1.5.1.Судалгаа хөгжүүлэлтийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийг эрчимжүүлэх хүрээнд:

1.5.1.1.Шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.5.1.2.Дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан тэргүүлэх чиглэл, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг хөгжүүлэх үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслүүдийг тодорхойлж, санхүүжилтийг шийдвэрлэнэ.

1.5.1.3. Үндэсний шинжлэх ухаан, технологийн санд асуудал болон үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлж, судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

1.5.1.4. Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.5.1.5. Хувийн хэвшлийн шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа, судалгаа хөгжүүлэлтийн ажил, технологи дамжуулалт, ашиглалтыг төрөөс дэмжих хамтарсан санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ.

1.5.1.6. Сансар огторгуйн шинжлэх ухааныг дагасан технологийн дэвшил, Марс гарагийн судалгаа, хөгжүүлэлт, инновацийн олон улсын хамтын үйл ажиллагаа эрхлэх технологийн парк байгуулахыг дэмжинэ.

1.5.1.7. Шинжлэх ухаан, технологийн болон аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн үндэсний технологи дамжуулах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.

1.5.1.8. Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.

1.5.1.9. Салбар дундын, салбар дамнасан судалгаа хөгжүүлэлтэд түшиглэсэн хүрээлэн байгаа орчин, нийгэм, эдийн засаг, засаглалын цогц нэгдэл бүхий шинжлэх ухаан, технологийн паркийн төслийг хэрэгжүүлнэ.

1.5.2. Хиймэл оюун ухаан, мэдээллийн технологийн үндэсний дэд бүтцийг хөгжүүлж, дижитал шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд:

1.5.2.1. Үндэсний хиймэл дагуул бүтээх, хөөргөх бэлтгэл ажлыг хангана.

1.5.2.2. Нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

1.5.2.3. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын газрын станц байгуулна.

1.5.2.4.Дрон ашиглалтын талаарх эрх зүйн орчныг бүрдүүлэх, туршилтын бүс байгуулах ажлыг эхлүүлнэ.

1.5.2.5.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах ажлыг эхлүүлнэ.

1.5.2.6.Шинжлэх ухааны виртуал парк байгуулах төслийг хэрэгжүүлнэ.

1.5.2.7.Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, газар зүйн мэдээллийн систем, блокчэйн технологийг ашиглан шинжлэх ухааны нотолгоонд суурилсан, хөгжлийн бодлого боловсруулах орон зайн цахим дэд бүтцийг байгуулна.

1.5.2.8.Олон улсын цахим төлбөрийн системийг өргөжүүлж, төлбөр тооцоог хүлээн авах, цахим худалдааны арга хэлбэрийг нэмэгдүүлнэ.

Хоёр.Бүсчилсэн хөгжлийн бодлого

2.1.Байгалийн баялаг, нөөц, байршлын давуу талд тулгуурласан бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлнэ.

2.1.1.Хангайн бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд хот байгуулалтын дэд бүс” болгон хөгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.1.1.Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх, соёлын аяллыг хөгжүүлж, археологийн нөөцөд тулгуурласан “Төв Азийн түүх, соёлын голомт” соёлын аялал жуулчлалын цогцолборыг байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.1.1.2.Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтад шаардлагатай суурь судалгаа, иж бүрэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусгана.

2.1.1.3.Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтыг эхлүүлэх бэлтгэл үе шатыг хангана.

2.1.1.4.Шинэ Хархорум хотын усны хэрэгцээг хангах төслийн бэлтгэл ажлыг хангана.

2.1.1.5.Мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто замын төслүүдийг эрчимжүүлж, нийслэл Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн авто замыг өргөтгөн шинэчлэх ажлыг эхлүүлнэ.

2.1.1.6.Хангайн бүсэд баригдаж байгаа дулааны станц барих төслүүдийг цахилгаан хангамж, дэд бүтцээр холбоно.

2.1.2.Баруун бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн бүс бүхий байгалийн аялал жуулчлалын дэд бүс” болгон хөгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.2.1.Алтайн нуруу, бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн адал явдалт, тусгай сонирхлын, хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Их нуурууд, Отгонтэнгэр хайрханд тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүс байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.1.2.2.Асгатын мөнгөний ордын нөөцийг тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах бэлтгэл ажлыг хангана.

2.1.2.3.Хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк, эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан дэвшилтэт технологийн шохойн үйлдвэр, Алтайн нурууны байгаль, соёлын өвийг түшиглэсэн эко парк, цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.1.2.4.Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төсөл, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийн санхүүжилтийг шийдвэрлэнэ.

2.1.2.5.Бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд хилийн боомтуудтай холбогдох босоо тэнхлэгийн авто замын төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.1.2.6.Дулааны цахилгаан станц болон дэд станцын өргөтгөл, цахилгаан дамжуулах шугамын төслийг хэрэгжүүлж, бүсийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлнэ.

2.1.2.7. Баруун бүсэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

2.1.3. Хойд бүсийг “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс” болгон хөгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.3.1. Бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүс байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.1.3.2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төслийг эхлүүлнэ.

2.1.3.3. Эгийн голын 315 МВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станц төслийн Байгаль нуурын эко систем болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн судалгааг боловсруулна.

2.1.3.4. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлалыг дэмжих босоо тэнхлэгийн авто замын төслийг хэрэгжүүлж, цахилгаан хангамж, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.

2.1.4. Говийн бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бөгөөд ногоон эрчим хүчний дэд бүс” болгон хөгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.4.1. “Тавантолгой” үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн кокс-химийн үйлдвэрийн төслийг эхлүүлнэ.

2.1.4.2. Тавантолгойн бүлэг ордыг түшиглэн хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, “Алтанширээт” үйлдвэрлэл, технологийн парк, “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.1.4.3. Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг эхлүүлнэ.

2.1.4.4. Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын төслийн бэлтгэл ажлыг хангаж, санхүүжилтийг шийдвэрлэнэ.

2.1.4.5. Хэрлэн-Тооно, Орхон-Онги төслүүдийн бэлэн байдлыг хангуулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

2.1.4.6. Говийн бүсийн аж үйлдвэрийг дэмжих хүрээнд тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээнд холбох авто замын төслүүдийг хэрэгжүүлнэ.

2.1.5. Төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс” болгон хөгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.5.1. Дархан-Сэлэнгийн бүс нутагт металл боловсруулах болон металл бүтээгдэхүүний үйлдвэр, дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.1.5.2. Хөшигийн хөндий болон Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулна.

2.1.5.3. Төвийн бүсийн хөнгөн аж үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн төслийг хэрэгжүүлнэ.

2.1.5.4. Төвийн бүсийн малын гаралтай түүхий эд, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

2.1.5.5. Бүс нутгийн эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

2.1.5.6. Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станцаас өргөх станцын хамт дулааны шугам барьж суурьшлын бүсийг дулаанаар хангах төслийн бэлэн байдлыг хангана.

2.1.5.7. Төвийн бүсийн хүнсний үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн төслийг хэрэгжүүлнэ.

2.1.6.Зүүн бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон хөгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.6.1.Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх хүрээнд Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтан овоо, түүхэн аялал жуулчлалын газар нутгийг дэд бүтцээр холбох, усан боомт байгуулах төслийг эхлүүлнэ.

2.1.6.2.Зүүн бүсийг эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүсийн хувьд хөдөө аж ахуйн экспортыг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.1.6.3.Зүүн бүсийг Говийн бүстэй интеграцчилан хөгжүүлж, кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс-эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.1.7.Бүс, орон нутагт ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд:

2.1.7.1.Нийслэл Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, нийслэл Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн зээлийг 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.1.7.2.Нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар нэгж болон салбарын нийт албан хаагчийн 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.1.7.3.Нийслэл Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих 1 хувийн хүүтэй 500 сая төгрөг хүртэлх зээл олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.1.7.4.Бүсийн хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг хангах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.7.5.Орон нутагт чөлөөт бүс, тусгай бүс, аж үйлдвэрийн парк байгуулж, боомт, хөрш орны хотуудтай холбогдох ажлыг эхлүүлнэ.

2.1.7.6.Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлнэ.

2.1.7.7.Стандартын шаардлага хангасан хүнс, эм, хүрээлэн байгаа орчны бүсчилсэн лабораторийн нэгдсэн тогтолцоог бий болгож хөгжүүлнэ.

2.1.7.8.Бүсүүдийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэн хөгжүүлж, салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

2.1.7.9.Бүс нутгийн эдийн засгийн төрөлжилтөд нийцсэн экспортын хөнгөн үйлдвэрийн кластерыг хөгжүүлэхэд хувийн хэвшлийг дэмжинэ.

2.1.7.10.Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүсчилсэн татварын тухай хуулийн төслийг боловсруулан татварын бодлогын үзэл баримтлалыг шинэчилж, холбогдох эрх зүйн орчныг сайжруулна.

2.1.7.11.Бүсчилсэн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу бүс бүрд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын төслийн бэлтгэл хангах, техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх, зураг төсөв, судалгааны ажлыг үргэлжлүүлнэ.

2.1.7.12.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

2.2.“20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040” болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.

2.2.1.Богдхан уулыг тойрч Тэрэлж, Налайх, Майдар хот, Зуунмод хот, Хөшигийн хөндий, Аргалант-Эмээлт хот, Жаргалант, Рашаант хотыг холбосон Шинэ их тойруу хурдны авто зам, хөнгөн галт тэрэгний төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

2.2.2.Нийслэл Улаанбаатар хотын авто замын стандартыг сайжруулах, зам, тээврийн сүлжээг өргөтгөх, хувийн хэвшил хөрөнгө оруулалт хийх, төлбөртэй зам барих нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

2.2.3.“Сэлбэ сэргэлт” төслийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.

2.2.4.Нийслэл Улаанбаатар хотын засаглалыг сайжруулах хүрээнд:

2.2.4.1.Нийслэл Улаанбаатар хотод хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбогдсон хуулийн зохицуулалтыг сурталчлан таниулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.2.4.2.Хөшигийн хөндийд баригдах инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийн эхний ээлжийн бүтээн байгуулалтыг олон улсын байгууллага, хувийн хэвшилтэй хамтран эхлүүлнэ.

2.2.4.3.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах оновчтой шийдлүүдийг авч хэрэгжүүлнэ.

2.2.4.4.Хотын стандартыг шинэчлэн боловсруулна.

2.2.4.5.Тусгай хэрэгцээг хангасан, иргэнд ээлтэй, дулааны алдагдал багатай амины орон сууцны загвар зураг боловсруулж батлах, ипотекийн зээлд хамрагдах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, ипотекийн зээл олгоход нийцсэн загвар төслийг батлах, олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулах, жишиг төсөл, загварын нээлтийг хийнэ.

2.2.4.6.Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд орлогод нийцсэн, өртөг багатай орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, шаардлагатай төсөл, арга хэмжээг эхлүүлнэ.

2.2.4.7.Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал, угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор олон улсын стандартыг шууд ашиглахыг судлах, хот байгуулалтын стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох судалгааны ажлыг эхлүүлнэ.

2.2.4.8.Хууль бусаар олгосон газрыг нийтийн эзэмшлийн газар болгож, уг газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах ногоон байгууламж, цэцэрлэгтэй болох нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.4.9.Хот төлөвлөлт, орчны стандарт алдагдсан орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлнэ.

2.2.4.10.Хот төлөвлөлтийн дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.

2.2.4.11.Орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлж, эрүүл, аюулгүй, амар тайван орчин бүхий хотыг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.4.12.Нийслэл Улаанбаатар хотын төвийн бүс, хүн амын төвлөрөл ихтэй бүсэд аюултай ачаа тээвэрлэхгүй байх зохицуулалтыг хийнэ.

2.2.4.13.Хяналтын камер, урсгал мэдрэгч төхөөрөмжүүдийг иж бүрэн суурилуулан, хотын хөдөлгөөн, бохирдол, эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдлын мэдээллийг цаг алдалгүй авч шинжилгээ хийх, зохицуулах арга хэмжээ авах системийг нэвтрүүлж, хиймэл оюун ухаанд суурилсан гамшгийн эрсдэлийн удирдлага, менежментийг хөгжүүлнэ.

2.2.4.14.Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн голын эргийн хамгаалалтын 30 км далан болон ус зайлуулах 100 км сувгийг шинээр барьж, дөрвөн байршилд усан сан, хөв, цөөрөм байгуулж, хот доторх гол, горхины урсцад тохируулга хийнэ.

2.2.4.15.“Туул усан цогцолбор төсөл”-ийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, ундны ус, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

2.2.4.16.Нийслэл Улаанбаатар хотын авто замуудыг хооронд нь холбох Шинэ тойрог авто зам, Туулын хурдны замыг барих, ачаа тээврийн хөдөлгөөнийг хотын гадуур тойруулах

болон Туулын замыг Нисэхийн хурдны авто замтай холбож, Наадамчдын авто зам дээгүүр гүүрэн байгууламж барих төслийг хэрэгжүүлнэ.

2.2.4.17.Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөөний дагуу 17.7 км “Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1” байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

2.2.5.Түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд:

2.2.5.1.Нийслэл Улаанбаатар хотын авто замын сүлжээний ачааллыг бууруулж, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоо, нийтийн тээврийн чиглэл, хуваарилалтыг бүрэн оновчтой болгоно.

2.2.5.2.Нийслэл Улаанбаатар хотод тойрог замын зохион байгуулалт хийж, замын хөдөлгөөний эрчмийг 30 хувиар нэмэгдүүлж, их өгөгдөлд үндэслэн автобусны сүлжээ, чиглэлийг оновчтой тодорхойлж, төлбөрийн системийг хялбарчилж, хүн амын нягтаршилд тохируулж, нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоо, нийтийн тээврийн чиглэл, хуваарилалтыг дахин төлөвлөнө.

2.2.5.3.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төвийн системд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, гэрлэн дохионы зохицуулалтыг хөдөлгөөний урсгалаас хамаарч ухаалгаар зохицуулах боломжийг бүрдүүлнэ.

2.2.5.4.Нийслэл Улаанбаатар хотын бүх чиглэлд дугуйн болон явган хүний замын бүрэн төлөвлөлтийг хийнэ.

2.2.5.5.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний иж бүрэн ухаалаг системийг нэвтрүүлж, хотын гэрлэн дохионы удирдлага менежментийг ухаалаг системд шилжүүлнэ.

2.2.5.6.Дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.

2.2.5.7.Гэр хороолол, дэд төв, дагуул хотуудад орон сууц барьсан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.

2.2.5.8.Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.2.5.9.Нийслэл Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийг шинээр барьж, өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.2.5.10.Нийслэл Улаанбаатар хотын Их тойруу, Бага тойруу буюу 770 га газарт төвлөрсөн төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу “Go Mongolia” ган татлагат гүүрний төсөл, Хөшигийн хөндийн туннелийн төслийг хэрэгжүүлнэ.

2.2.6.Дагуул хотуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэх ажлын хүрээнд:

2.2.6.1.Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, чиг үүргийг шилжүүлэх хүрээнд Шинэ Зуунмод хотод төрийн захиргааны төв байгууллагуудыг үе шаттайгаар шилжүүлэн байршуулж, олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, аялал жуулчлалын цогцолбор, ачаа тээврийн нэгдсэн логикийн төв, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, их сургуулийн хотхон бүхий аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлнэ.

2.2.6.2.Шинэ суурьшлын бүс байгуулах ажлыг эрчимжүүлж, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжин төвлөрлийг сааруулна.

2.2.6.3.Улсын зэрэглэлтэй хотын дэд бүтцийг эрчимжүүлж, эдийн засаг, санхүүгийн хувьд бие даасан байх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.6.4.Аялал жуулчлал, тээвэр, логистик, олон улсын санхүүгийн төв, эдийн засгийн чөлөөт бүс бүхий эко-ухаалаг Шинэ Зуунмод дагуул хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна.

2.2.6.5.Нийслэл Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг үргэлжлүүлэн чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийн төслийг хэрэгжүүлнэ.

2.2.6.6.Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгана.

2.2.6.7.Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг дүүрэг бүрд байгуулна.

2.2.6.8.Номтын аманд эрчим хүчний хэмнэлттэй төр захиргааны нэгдсэн байрыг барьж байгуулна.

2.2.6.9.Налайх, Багануур зэрэг улсын зэрэглэлтэй хотын дэд бүтцийг эрчимжүүлж, эдийн засаг, санхүүгийн хувьд бие даасан байх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.6.10.Шинэ Зуунмод хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан “Цахиурын хөндий” дата төв, хүлэмжийн болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлнэ.

2.2.6.11.45000 тонн нарийн ногоо хураах өвлийн хүлэмжийн кластер бүхий Агросити эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг эхлүүлнэ.

2.2.6.12.Олон улсын санхүүгийн төв байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гурав.Хүний хөгжлийн бодлого

3.1.Үндэсний орон сууцжуулах бодлогыг Үндэсний баялгийн сантай уялдуулан хэрэгжүүлнэ.

3.1.1.Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд:

3.1.1.1.Нийслэл Улаанбаатар хот, орон нутагт өрхийн төлбөрийн чадварт нийцүүлэн ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.1.2.Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зориулалттай Хуримтлалын сангаас иргэдэд орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.

3.1.1.3.“Миний анхны байр”, “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Миний амины орон сууц”, “Миний сонголт орон нутаг”, “Миний сонголт төрийн алба” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.1.4.Ипотекийн зээлийн 50-аас доошгүй хувийг дэд төв, дагуул хот, гэр хорооллын өрхөд олгоно.

3.1.1.5.“Хашаандаа сайхан амьдарья” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц шинээр барих, засварлахад хөнгөлөлттэй зээл болон бусад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.1.1.6.Гэр хорооллын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан иргэдэд санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ.

3.1.1.7.Гэр хорооллын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон, пассив барилгын стандарт болон ногоон санхүүжилтийн шаардлага хангахуйц бие даасан инженерийн шийдэлтэй загвар хорооллыг хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн барьж байгуулна.

3.1.2.Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг байгальд ээлтэйгээр хөгжүүлэх хүрээнд:

3.1.2.1.Эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй, ногоон барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн санхүүжилт, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.1.2.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүй, стандартыг боловсронгуй болгож, барилга байгууламжийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.2.3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, цементийн үйлдвэрүүдийг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.1.2.4.Үл хөдлөх салбарын хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.1.2.5.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоог багасгах зорилгоор барилгын салбарын төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод үе шаттайгаар шилжүүлж, дагалдах хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.

3.1.3.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд:

3.1.3.1.Барилга, орон сууцны ашиглалтын эрх зүйн орчныг шинэчилж, орон сууц ашиглалтын контор болон сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулна.

3.1.3.2.Хүн амын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хүртээмжтэй, тогтвортой, чанартай үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.1.3.3.Ус бохирдуулагч үйлдвэр, үйлчилгээний салбарын хаягдал усны хяналтыг сайжруулна.

3.2.Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөхүйц чадвартай төгсөгчдийг бэлтгэнэ.

